

МОНГОЛ СУДЛАЛЫН
ИНДЭР

НЭРТ ЭРДЭМТДЭЭС
АВСАН ЯРИЛЦЛАГА

1987 онд Улаанбаатар хотноо хуралдсан ОУМЭ-ийн V их хурлын үеэр тус сэтгүүлийн редакци хуралд оролцсон зарим эрдэмтдэд хандаж дараахь 4 зүйлийн асуулт тавьсан юм. Асуулт нь:

1-рт: Монгол судлалын ямар сэдвээр голлон мэргэшсэн:

2-рт: Сүүлийн үеийн бүтээл, цаашдын төлөвлөгөө.

3-рт: «Дорнодахины судлалын асуудал» сэтгүүлд нийтлүүлэхийг хүсэх өгүүлэл буй эсэх, байвал өгөх буюу явуулах,

4-рт: ОУМЭ-ийн V их хурлын талаар ямар сэтгэгдэл төрсөн эдгээр болно

Ярилцлага авсан 4 эрдэмтний хариултыг дор нийтэлж байна. Харин тэдгээрийн ирүүлсэн өгүүллийг энэ удаагийн дугаарт зай хүрэлцэхгүй байгаа тул дараагийн дугаарт нийтлэх учрыг хамтад толилуулъя.

(Редакци)



С. К. РОШИН (ЗХУ)

Эдийн засгийн ухааны дэд эрдэмтэн,
ЗСБНХУ-ын ШУА-ийн Дорнодахины
судлалын хүрээлэнгийн секторын эрхлэгч

1. Монгол судлалын салбар дахь миний судалгааны ажлын үндсэн чиглэл бол БНМАУ-ын шинэхэн түүх, эдийн засгийн асуудлууд юм. Тус орны хөдөө аж ахуйн социалист өөрчлөлт, социалист үйлдвэрлэлийн харилцааны үүсэл, хөгжил, капиталист биш хөгжлийн зам хийгээд бусад асуудлыг судлахад би голлон байна.

2. Сүүлийн үеийн бүтээл гэвэл, Зөвлөлт-Монгол эрдэмтдийн «БНМАУ-ын түүх» (гуравдахь хэвлэл), «БНМАУ-ын социалист эдийн засгийн түүх» гэсэн Зөвлөлт-Монголын эрдэмтдийн хамтын нэгэн сэдэвт зохиол, «Пролетарийн интернационализм ба Азийн социалист орнуудын хөгжил», «Азийн орнууд дахь социалист эдийн засгийн байгуулалтын туршлага» гэсэн хамтын бүтээл, «Бүгд Найрамдах Монгол Ард Улс» гэсэн лавлахыг бичиж, редакторлахад оролцлоо. «БНМАУ дахь социалист

үйлдвэрлэлийн харилцааны хөгжил» гэсэн миний номыг 1986 онд Улаанбаатар хотноо монгол хэлээр орчуулан гаргасанд би монгол нөхөддөө, ялангуяа орчуулагч Д. Төмөртогод гүнээ талархаж байна.

Энэ таван жилд «БНМАУ-ын капиталист биш хөгжлийн түүхэн туршлага ба социалист чиг баримжааны орчин үеийн асуудлууд», Зөвлөлт Монголын эрдэмтдийн хамтын нэгэн сэдэвт зохиол «Азийн орнуудын социалист хөгжлийн түгээмэл хийгээд онцлог талууд», «Дорно дахины түүх» хамтын бүтээлийг бичиж бэлтгэхэд оролцож байна. Цаашдаа БНМАУ феодализмаас социализмд шилжсэн шилжилтийн үеийн эдийн засгийн асуудлуудыг нэгтгэн дүгнэх сэдвээр нухацтай ажиллана гэж бодож байна.

3. Танай сэтгүүлд нийтлүүлэх өгүүлэлд хэрэв зөвшөөрвөл Монголч эрдэмтдийн V их хурал дээр тавьсан илтгэлээ санал болгох хүсэлтэй байна. (Бүрэн эхийг хавсаргав). Сэтгүүлийн редакцийн үзэмжээр илтгэлийг товчлон нийтэлж болно.

4. Монголч эрдэмтдийн V их хурал нь БНМАУ-ын соёл, шинжлэх ухааны амьдралд төдийгүй дэлхийн монгол судлалын хөгжилд томоохон үйл явдал боллоо. Энэ их хурал олон орны монгол судлалд онцгой байр эзлэнэ. Нэгдүгээрт; Их хурал монгол судлалын бүхий л түүхийн турших хамгийн том чуулга болж, түүний ажиллагаанд 33 орны нийт 200 орчим төлөөлөгч оролцлоо. БНМАУ, ЗХУ, БНХАУ, БНАГУ, БНУАУ, Япон, АНУ, ХБНГУ зэрэг орноос хамгийн олон төлөөлөгч байв. Хоёрдугаарт; Их хурлаар олон улсын монголын судлалын холбоог (ОУМСХ) байгуулсан нь нэн чухал зүйл мөн. Ийм байгууллага байгуулах цаг нэгэнт болжээ. Эдүгээ дэлхийн олон арван оронд Монгол судлалын ажлыг хийж байгаагаас олонхид нь монгол судлаачдын үндэсний нийгэмлэг ажиллаж байна. 1987 оны 5-р сард ЗХУ-д Бүх Холбоотын Монгол судлаачдын Холбоо байгуулагдлаа. ОУМЭ-ийн V их хурлаар ОУМСХ-г байгуулсан нь олон орны монгол судлаачдын хүч чармайлтыг нэгтгэх, тэдний хоёр талын болон олон талын хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн бэхжүүлэхэд тус дөхөм болох нь эргэлзээгүй. Олон улсын монгол судлалын төв штаб нь дэлхийн монгол судлалын нийтээр хүлээн зөвшөөрсөн төв—БНМАУ-д байх ёстойн талаар хуралд оролцогчид санал нэгтэй байлаа.

ОУМЭ-ийн V их хурал Монголын тухай шинжлэх ухааны ололт амжилтыг нэгтгэн үзсэн тайлан болсон юм. Түүхч, эдийн засагч, хэл шинжлэгч, соёл судлаачид судалгааныхаа сүүлийн үеийн үр дүнг их хуралд илтгэж, онол, практикийн их ач холбогдолтой, шинжлэх ухааны чухал дүгнэлт хийлээ. Ихэнх буюу 100 орчим илтгэл нь монгол эрдэмтдийнх байсныг тэмдэглэхэд таатай байна. Тэдний илтгэл шинжлэх ухааны нарийн төвөгтэй, бага судлагдсан, чухал асуудлыг хөндсөнөөрөө онцлог юм. Энэ бүхэн Монголын шинжлэх ухааны өсөн нэмэгдэж буй ололт амжилт, нэр хүндийг харуулж байна.

Их хурал амжилттай болж, монгол судлалын цаашдын хөгжилд их ач холбогдолтой, чухал үр дүнд хүрлээ. Их хурлыг маш сайн бэлтгэн явуулж, үр бүтээлтэй ажиллах бүхий л нөхцөлийг хангасан монгол нөхөддөө чин сэтгэлээсээ талархал илэрхийлэхийг хүсэж байна. Шинжилгээ судалгааны үлэмж өндөр түвшин, хамтын ажиллагаа өргөжин гүнзгийрснээрээ ялгарах монголч эрдэмтдийн энэ Их хурал дэлхийн Монгол судлалын хөгжилд шинэ үе нээлээ.

Зөвлөлт Монголын эрдэмтэд хэзээнээс нааш нягт хамтран ажиллаж ирсэн бөгөөд хамтран ажиллах хамгийн янз бүрийн хэлбэрийг бид идэвхтэй хэрэгжүүлдэг тул Их хурлаас хойш ч бидний шинжлэх ухааны бүх талын хамтын ажиллагаа улам бүр эрчимтэй, үр бүтээлтэй болно гэдэгт итгэж байна.



Проф. ДЭНИС СИНОР (АНУ)
АНУ-ын Индиана их сургуулийн хүндэт
профессор, Унгарын ШУА-ийн хүндэт
гишүүн, Алтай судлалын Олон улсын
байнгын бага хурлын (ПИАК) Ерөнхий
нарийн бичгийн дарга

1. Би Будапештын их сургуульд проф. Луис Лигети талийгаачийн тусламжтайгаар 1934 онд сонгодог Монгол хэл судалж эхэлсэн юм. Тэгэхэд заалгасан хичээл намайг хожим Кэмбриджийн их сургууль (Англи)-ийн Дорнодахины судлалын факультетийн гишүүн болж сонгодог монгол хэлээр багшлахад их хэрэг болсон. Энэ их сургуулийн 700 жилийн түүхэнд монгол хэлийг анх удаа зааж эхэлсэн нь тэр байв. Их сургуулийн хичээлийн программд монгол хэлийг тийнхүү оруулсандаа би одоо хүртэл баяртай явдаг юм.

Харин харамсалтай нь Индиана их сургууль (Блумингтон)-д ажиллахаар Кэмбриджээс 1962 онд намайг явахад уг хичээл орохоо больсон юм. Индиана их сургуульд очоод сонгодог ба орчин үеийн монгол хэлний хичээлийг профессор Хангины Гомбожав, Джон Крюгер нарын мэргэжил нэгтнүүддээ даатгав.

Би өөрийгөө «монголч» гэдэг нэрийн жинхэнэ утгад тохирохгүй байх гэж боддог. Учир нь над орчин цагийн монгол хэл сурах зав байгаагүйн дээр монгол хэл, утга зохиолоор хэвлүүлсэн бүтээл маш бага билээ. Гэхдээ Алтайн харьцангуй хэл шинжлэлээр нийтлэгдсэн бүтээлүүддээ монгол материал тууштай хэрэглэж байсан.

Түүхийн арвин их сэдвээс би 1-д Түрэг, Уйгар гэх мэт дундад зууны түрүү үеийн Монголын судлал, 2-т 13-р зууны агуу их Монголын эзэнт улсын өрнөд хэсгийн хувь тавилан, ялангуяа түүний Европтой хэрхэн холбогдож ирсэн талыг нарийвчлан судлахад гол анхаарч байна.

Цаашдын төлөвлөгөө гэвэл миний редакторлож байгаа Өвөр **Азийн Кэмбридж түүх**-ийн ботид «Монголчууд өрнө дахинд» гэдэг эссэ нийтлэгдэнэ. Энэхүү томоохон бүтээлийн 1 ботийг 1988 онд гаргах төлөвлөгөөтэй.

Одоогоор 1304 онд Армений Жонон Гэйтоны бичсэн нэгэн чухал бүтээлийн хуучин франц эхийн тайлбартай орчуулга дээр сууж байна. Энэ ажлыг Унгарын профессор Эдмонд Считс, Индиана Их сургуулийн профессор Мэнуэл Мискел нарын хамт гүйцэтгэж байна. Энэ бол Монгол түүхийн төдийлөн мэдэгдээгүй томоохон сурвалж юм. Цаашилбал, **Азийн Түүхийн сэтгүүлчийн** дараачийн дугаарт (боть 22, 1) Монгол түүхийн сүүлийн үеийн бүтээлээр хийсэн миний номзүйн нэлээд дэлгэрэнгүй тэмдэглэл гарах учиртай.

3. **Дорно дахины судлалын асуудал** сэтгүүлд би «Монгол түүхийн сурвалж болох Джоинвиллийн ноён Джоны дурсамж» гэдэг бяцхан өгүүллээ зориулан өргөж байна.

4. Би БНМАУ-д анх 1970 онд ирснээс хойш гуравдахиа ирээд байна, эртний үндэстний амьдралд арван долоон жил ахар богино хугацаа боловч тэдгээр жилүүдэд монгол амьдралд гарсан өөрчлөлт над чухал мэт санагдлаа. Би хот суурины хөгжилт юм уу амьдралын түвшингийн ерөнхий өсөлт зэрэг тоо томшгүй дэвшлийг дурдах гэсэн юм биш. Тэдгээр нь хэдийгээр чухал боловч тоо бүртгэл данс хард тусгагдаж тэндээс амархан харагдах билээ. Анзаарагдах нь бага боловч ач холбогдол ихтэй нэг зүйл бол гадаад харилцаанд нь гарч буй нааштай хандлага гэж хэлмээр байна. Улс төрийн бодлогод нь соргог өөрчлөлт гарч «Монголын» өвөрмөц шинж чанараа огтхон ч үгүйсгэхгүйгээр олон улсын байдалд улам бүр нийцүүлэх болж байгааг мэдэрч байна. Тухайлан хэлэхэд, шүүмжлэл бол дайсагнах үзлийн илэрхийлэл байхаасаа эв найрамдал эерэг санааны шинж тэмдэг болох нь давдаг тал бишгүй байдгийг танин мэдэж өөртөө итгэх итгэл өсөн нэмэгдэж буйд сэтгэл нэн таатай байна.



Проф. ЦАЙ МЭЙБЯО (БНХАУ)
Хятадын нийгмийн шинжлэх ухааны
Академийн нэн шинэ түүхийн хүрээлэн

1. Би нэг сургуульд суралцаж байх үедээ «Нууц товчоо»-г уншсан тэр үеэс Монголын түүхийг сонирхох эхэлсэн юм. Би «Нууц товчоо дахь эртний монголчуудын урлах ёс заншлын тухай» хэмээх Монголын түү-

хийн холбогдолтой анхныхаа өгүүллийг 1947 онд Тяньзиний «Иши бао» гэдэг түүх газар зүйн долоо хоног тутмын сэтгүүлд нийтлэв.

Дараа нь эртний хөшөөний бичээсийн материалд тулгуурлан «Ляо, Алтан улсын үеийн хөшөөний бичээс дахь Татар гэдэг үгийг нягталж судалсан нь» гэдэг өгүүллийг бичиж нийтлэв.

Би 1949 онд Бээжин их сургуулийн аспирантурт суралцаж байхдаа Монголын түүхийг дагнан судалж эхлэв. Энэ үед Бээжин их сургуулийн дорно дахины хэл бичгийн ангид Монгол хэл сурах завшаан надад олдсон юм. 1950, 1952 онд Өвөр Монголын Хөлөн буйр болон зүүн хойт Хятадын үндэсний цөөнхийн районд нийгэм, түүх, хэл шинжлэлийн экспедицэд удаа дараалан оролцон ажиллаж, хэл шинжлэлийн талаар хийсэн судалгааны тайлан хоёрыг бичиж нийтлэв. 1950 оноос хойш би Бээжингийн их сургуулийн нийгмийн ухааны хүрээлэнгийн Алтан улсын үеийн чулуун барын тасагт ажиллаж байхдаа тус хүрээлэнд хадгалагдан байсан өдий төдий чулууны бичээсийн материал дотроос түрүүчийн хүмүүс гар хүрээгүй байсан дөрвөлжин үсгийн хөшөөний бичээс ба хятад үсгээр хялбарчилж орчуулсан чулуун барын материалыг олов. 1954 онд «Юан улсын үеийн хөшөөний жир бичээсийн эмхэтгэл» гэдэг номыг найруулж хэвлүүлэв. Дараа нь хэл шинжлэлийн эрдэмтэн Ло Чанпэй багштай хамтран «Дөрвөлжин үсэг ба Юан улсын үеийн хятад хэл» гэдэг ном бичиж 1959 онд хэвлүүлэв. 1952 оноос хойш Хятадын ШУА-д ажиллав. Эхлээд хэл шинжлэлийн хүрээлэнд, дараа нь шинэ түүхийн хүрээлэнд шилжин ажиллаж, талийгаач түүхч Фань Вэньлань багштай хамтарч «Хятадын түгээмэл түүх»-ийн олон боть зохиолыг туурвих ажилд туслав. Фань Вэньлань насан эцэслэсний дараа би уг ажлыг үргэлжлүүлэн «Хятадын түгээмэл түүх»-ийн 5—10-р ботийг туурвих ажлыг хариуцан хийв. Үүнд Сүн улсын үеэс Чин улсын үеийн Хятадын түүх хамаарагдах юм. Миний судалгааны ажлын хүрээ аажмаар өргөжсөн учраас Юан, Мин, Чин улсын үеийн Монголын түүхийг дэс дараатай, нарийвчлан судлахгүй бол болохгүй байв. Иймд би «Хятадын түгээмэл түүх»-ийн 7, 8, 9, 10-р ботиудад монголын түүхийн хөгжлийн талаар нэлээд хэмжээгээр нэмэлт болгон оруулж туурвисан тул Монголын түүхийн талаар би өөрийнхөө үндсэн ойлголт, үзэл бодлыг тэдгээр номуудад үндсэнд нь багтаасан болно.

2. Сүүлийн үед би Юан улсын түүхийг судлах Хятадын нийгэмлэгийн дарга, Монголын түүхийг судлах Хятадын нийгэмлэгийн тэргүүлэгчээр сонгогдсон бөгөөд Монголын түүхийн судлалын талаар дээрх эрдэм шинжилгээний байгууллагаас эрхлэн гаргадаг «Юан улсын түүхийн цуврал», «Монголын түүхийн судлал» гэдэг хэвлэлүүдэд Монголын түүхийн тухай өгүүлүүдийг нийтэлж байв. «Жю ба Жю-гийн цэргийн өөрчлөлт» гэдэг өгүүлэлдээ Жю ба Чагут гэдэг үгний холбоог нягталж, Чингис хааныг хаан ширээнд суухаас өмнө Чагутхури гэдэг цол өргөмжилж байсан ба Монголын цэргийн зохион байгуулалтын талаар өөрийн тайлбарыг хийв. Мөн дээр үед цуглуулсан хөшөөний бичээсийн материалд тайлбар хийх ажлыг сүүлийн жилд үргэлжлүүлж хийж, «Цзинчжоу-гийн Шуй Цюань сы-гийн хөшөөний бичгийн тайлбар», «Хэ дун-гийн Янь Цзо сы (хийд)-гийн хөшөөний бичгийн тайлбар», «Юан ши-гийн кай хуа сы (хийд)-гийн хөшөөний бичгийн тайлбар» зэрэг өгүүлүүдийг нийтлэв.

1987 онд Олон улсын монголч эрдэмтдийн хурал дээр тавьсан «Турагана хатны түүхийг магадласан нь» гэдэг илтгэл бол миний хувьд Монголын түрүү үеийн түүхийг судалсан судалгааны сэдвийн нэг нь юм.

Ирэх хэдэн жилд миний бие монголын түүхийг судлах судалгааны хувьд монголын түрүү үеийн түүхийг голлон судлахад анхаарал тавихын зэрэгцээгээр, олон жилийн турш цуглуулсан материалд тулгуурлан «Дөрвөлжин үсгийн хөшөөний бичгийн тайлбар» гэдэг ном гаргах ба «Юан улсын үеийн хөшөөний жир бичээсийн эмхэтгэл», «Дөрвөлжин үсэг ба Юан улсын үеийн хятад хэл» зэрэг бүтээлдээ нэмэлт засвар хийж дахин хэвлүүлэх болно.

3. Монгол судлал бол судлагдахууны хувьд хүрээ хэмжээ ихтэй зүйл бөгөөд миний бие хязгаарлагдмал хүрээнд өчүүхэн зүйлийг хийх юм. Гэвч миний хийх гэж байгаа зүйл Монголын түүх, хэл бичгийн судлалд хувь нэмэр болно байх гэж найдаж байна.

Олон улсын Монголч эрдэмтдийн холбоо байгуулагдсан явдал бол олон улсын монгол судлаачдад баярлууштай үйл явдал боллоо. Монгол үндэстэн бол агуу их үндэстэн юм. Монгол үндэстэн хүн төрөлхтний түүхэнд томоохон нөлөө үзүүлж байсан ба хүн төрөлхтний соёл иргэншлийн дэвшилд ихээхэн хувь нэмэр оруулсан юм. Одоо Монгол үндэстэн дэлхийн олон улс ба нутаг оронд тархан суурьшжээ. Монголын түүх, хэл, уран зохиол нь өдий төдий улс орны шилдэг судлаачдын анхаарлыг зүй ёсоор татсаар иржээ. Гэвч аливаа орны монголч нар өөрийнхөө хараагаа зөвхөн тухайн орны хүрээгээр хязгаарлах нь хангалтгүй бөгөөд янз бүрийн орон, орон тус бүрийн материалыг өргөнөөр ашиглан баяжуулж, олон орны эрдэмтдийн судалгааны үр дүнг тусгаж байх нь зүйтэй юм.

4. Эдүгээ дэлхий дахинд шинжлэх ухааны аль нэг салбар олон улсын тухайн салбарын солилцоогоор дамжихгүй бол болохгүйн адил Монгол судлалаар олон улсын монголч эрдэмтэд нягт хамтран ажиллахыг шаардаж байна. 1987 онд Улаанбаатарт хуралдсан монголч эрдэмтдийн хурал БНМАУ-ын ШУА-ийн нөр их дэмжлэг ба хурлыг зохион байгуулагчдын хүчин чармайлтаар амжилттай явагдаж өнгөрөв.

Миний бие БНХАУ-ын Монгол судлаачийн хувьд тус хуралд уригдан оролцож, олон улсын Монголч нарын судалгааны байдлыг мэдэж, олон найз нөхөдтэй танилцсандаа маш их баяртай байна.

Олон улсын Монголч эрдэмтдийн холбооноос Монгол судлалын эрдэм шинжилгээний солилцоо, олон улсын Монголчдын хоорондын нөхөрлөлийг бэхжүүлж ажиллах талаар ашиг тустай хувь нэмэр оруулахыг би дотнотлон хүсье.

Хятад хэлнээс орчуулсан

Г. Гунгаа



Д-р. КАРОЛИНА ХАМФРИ
Их Британ. Кэмбриджийн их сургуулийн
Монгол ба Өвөр Азийн судлалын төв

1. Дагуур монголчуудын бөө мөргөлийн талаар Онон Өргөнгөөтэй хамтарч нэг ном бичиж байна. Энэ бол одоогоор миний хийж буй гол ажил. Нун голын дагууруудын 1920-1940-өөд оны үеийн шашин шүтлэг, мөргөлийн ёс заншлын талаар ноён Өргөнгөөтэй ярилцаж мундахгүй материалтай болж, түүнийгээ Хайссиг, Далай болон бусад судлаачдын бүтээлд гарч буй Дорнод Монголын бусад ястан болон Широкоголовын номонд дурьдсан хөрш зэргэлдээ Тунгус омгийнхны бөө мөргөлтэй харьцуулан, Латтимор, Баранов болон бусад эрдэмтдийн тодорхойлсон түүхэн нөхцөлтэй уялдуулж үзэх болно. Уг номд Өвөр Монголд Мэндсүрэн, Энхбат, Мэргэндий нарын болон бусад зохиогчдын ойрмогхон хэвлэгдсэн бүтээлүүд, 1987 оны зун Нун голын дагууруудын нутагт хийсэн шинжилгээний ажлын үедээ бичсэн соронзон хальсны бичлэг, авсан гэрэл зураг зэрэг материалыг ашиглах болно. Цуглуулсан мэдээ материалдаа тулгуурлан, миний бие энэхүү номондоо бусад эрдэмтдийн санал бодлыг тусган өөрийн үзэл бодлын үүднээс бөөгийн шашны талаар задлан шинжилгээ хийхийг зорьсон бөгөөд 1988 оны эцсээр дуусгахаар чармайж байна.

— Миний хийж буй ажлын өөр нэг хэсэг нь Халх монголчуудын оршуулах ёслолыг шинжилсэн антропологийн судалгаатай холбогдоно.

— Миний бие, мөн англиар яригчдад зориулсан орчин үеийн монгол хэлний сурах бичиг дээр ажиллаж байна. Энэ бол англи оюутнуудад монгол хэл зааж буй туршлагадаа түшиглэн ноён Б. Дамдингийн бичсэн ном бөгөөд түүнд нь би туслалцаж байгаа юм. Энэ ном өнөө үед хэрэглэж байгаа сурах бичгүүдийн дотор нэлээд дорвитой нь болох болов уу.

— Монгол ба Өвөр Азийн судалгааны төвийн захирлын хувьд би дор дурдсан хэдэн чиглэлээр явуулж буй судалгааг удирдаж байна. Үүнд: 1. Өвөр Монголын малчдад өнөөгийн эдийн засгийн өөрчлөлт хэрхэн нөлөөлж буй тухай; 2. 1921 оны Монголын хувьсгал үүсч хөгжсөн түүхийн судалгаа; 3. Дорнод Монголын ястнуудын дуу хөгжмийн (язгуур урлагийн— орч.) харьцуулсан судалгаа; 4. БНМАУ-ын баруун монголчуудын материаллаг соёл; 5. Өвөр Монгол, Баргын холбогдолтой баримт бичгийн түүхийн судалгаа эдгээр болно.

Манай төв ноён Б. Дамдингийн тусламжтайгаар эхлэн суралцагч, хоёр дахь жилийн болон сайн мэдэгчдийн гэсэн 3 түвшингээр монгол хэл, орчин цагийн болон хуучин үсэг зааж, судалгааны семинар тогтмол явуулж байна.

-- Монгол судлалын олон талыг хамарсан өгүүлэл, номын шүүмж хэвлэн гаргадаг Англи, Монголын нийгэмлэгийн сэтгүүлийг редакторлох ажлаа үргэлжлүүлэх бөгөөд сэтгүүлд гадны зохиогчдын материалыг дуртайяа хүлээн авна.

2. Монгол ба Өвөр Азийн судалгааны төвийн эрдэм шинжилгээний болон сургалтын ажлыг дэмжих, Британийн залуу эрдэмтдийн судалгааны шинэ сэдэв, төсөл боловсруулах, бусад орны, ялангуяа Монголын эрдэмтэн судлаачдын ажилд туслах, тэднийг судалгааны боломжоор хангах, тус төвөөс эрхлэн «Монгол ба Өвөр Азийн судалгааны бүтээлүүд» хэмээх сэтгүүлийг үе үе гаргаж байхаар тус тус төлөвлөж байна.

2. Монгол судлалтай холбоотой олон улсын байгууллагуудын ажиллагаанд оролцож, харилцан сонирхож буй чиглэлээр Монголын эрдэмтэдтэй хамтран ажиллана.

— Монгол судлалаар сүүлийн үед явуулж байгаа эх судалгаанд зориулан Кэмбрижэд олон улсын бага хурал зохион байгуулах. Үүнийг 1989 оны эхээр төлөвлөж байна.

— Монголын соёл, нийгмийн сэдвээр явуулж буй хувийн судалгаагаа үргэлжлүүлнэ. Орчин үеийн Халх Монголын гэр бүлийн асуудлаар сургалтын зориулалттай кино хийнэ. 1988 оны зун ЗСБН Автономит Тува улсын тухай телевизийн кино хийх ба цаашид Буриадын талаархи шинжилгээний ажлаа үргэлжлүүлнэ.

3. Цаашдаа Монгол ба Өвөр Азийн судалгааны төвийн гишүүд энэ сэтгүүлийг тогтмол хүлээн авч, мөн сэтгүүлд өгүүлэл явуулж байх бололцоотой гэж найдаж байна. Сэтгүүлийн ярилцлага, маргаан, номын шүүмж зэрэгт оролцож байхад дуртай байна.

4. ОУМЭ-ийн их хуралд, жилээс жилд тоо, чанарын хувьд ихээхэн сонирхолтой илтгэлүүд тавигдах болсон нь монгол судлал ихэд өргөжиж, өмнөх жилүүдийн нөр их ажил үр өгөөжтэй болж буйг харуулж байна. Өнгөрсөн жил (1987)-ийн хуралд гэхэд л бүгдтэй нь танилцаж амжимгүй тийм олон сонирхолтой илтгэл тавигдлаа. Хэдий тийм боловч бүх оролцогчидтой уулзаж учран, ярьж хөөрөх боломжтой олон учрал гарсан юм. Би хувьдаа урьд өмнө нь зөвхөн сонссоноос бус уулзаж учирч байгаагүй ЗХУ, Япон, БНАГУ-ын мэргэжил нэгт нөхөдтэй тааралдсандаа маш их баярласан билээ. ЗХУ болон Монголын төлөөлөгчид илтгэлүүдийнхээ хэвлэсэн товчлолтой байсан нь маш их тустай байв. Хэдийгээр зэрэгцсэн орчуулгын техникийн чанар өндөр биш байсан боловч зохион байгуулалтын ерөнхий түвшин ихээхэн сайн байлаа.

Олон улсын монголч эрдэмтдийн байгууллага бий болсон нь маш хэрэгтэй алхам бөгөөд ялангуяа янз бүрийн орны эрдэмтдийн хооронд холбоо тогтооход болон эрдэм шинжилгээний бүтээлээ хэвлүүлэхэд туславал их хэрэгтэйсэн. Тэгэхдээ хариу санал онол үл шаардагдах жирийн өгүүлэл хэвлээд зогсох биш харин тодорхой сэдвээр саналаа солилцох боломжийг бүрдүүлсэн тийм байгууллага байгууштай билээ. Олон улсын байгууллага Монголын талаар гарч буй томоохон чухал номуудын шүүмж, тойм хэвлэж байж болох юм.

Миний хувьд энэ их хуралд оролцсоноор монгол оронд дахин ирж цэцэглэн хөгжиж буй нийслэл хотыг үзэх, хуучин анд нөхөдтэйгөө нүүр учран золгох сайхан бололцоо олдсонд тун их баярласан билээ.

Англи хэлнээс орчуулсан Л. БЭГЗЖАВ